

ЗАСГИЙН ГАЗРЫН “ИРГЭД, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ТӨВ”-Д
ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ГОМДОЛ, ШҮҮМЖЛЭЛ, САНАЛ ХҮСЭЛТ, ТАЛАРХАЛ

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар үйлийн 16.1 дүгээр заалтыг баримтална.

№	Он, сар, өдөр, цаг, минут	Бүртгэлийн дугаар	Төрөл	Утга	Биелэлт
2022 оны эхний хагас жил					
1.	2022.01.04	0000122603	Гомдол	2021.12.15-ны өдөр 7950УБҮ гэсэн дугаартай тээврийн хэрэгслийн 20,000 төгрөгийн торгууль над дээр ирж байна. Надад ийм машин байхгүй. 7950УБҮ дугаартай сүүлийн 3 жил замын хөдөлгөөнд оролцоогүй машин байдаг. 102 дугаарт холбогдон энэ талаар лавлахад 2 дугаар өгсөн. Гэтэл тус дугаарууд нь огт утсаа авахгүй байна. Иймд холбогдох байгууллагад уламжлан арга хэмжээ авч өгнө үү. Мөн 6203УБД тээврийн хэрэгсэл дээр маань 2016 онд Сэлэнгэ аймагт дугаар авахаас өмнө торгууль бичигдсэн байсан.	Таны эзэмшлийн Toyota Carina маркийн 79-50 УБУ улсын дугаартай тээврийн хэрэгсэлд 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдөр 13 цаг 31 минутанд Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэр “Централ Таур”-ын урд замд МУ-ын ЗХД-ийн 11.10 дахь заалтыг зөрчсөн байх тул торгуулийн арга хэмжээ ногдуулсан нь 79-50 УБУ улсын дугаартай тээврийн хэрэгслийн торгууль андуурагдан илгээгдсэнийг засварлан 79-50 УБУ улсын дугаартай тээврийн хэрэгсэлд илгээсэн болно. Мөн Toyota Prius 20 маркийн 62-03 УБД улсын дугаартай тээврийн хэрэгслийн 2016 онд бичигдсэн торгууль нь таныг Toyota Prius 20 маркийн тээврийн хэрэгсэлдээ 62-03 УБД улсын дугаар авахаас өмнө бичигдсэн торгууль тул та энэ талаараа Авто тээврийн үндэсний төвд хандан шийдвэрлүүлэх тухай 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 14-1в/28 дугаартай албан бичгээр хариу хүргүүлэв.
2.	2022.01.19 10:48	128261	Гомдол	Оройн цагаар явахад замын цагдаа нар үлээлгэж байна гээд жижиг аппаратаар ам дамжуулан шалгаж байгаад гомдолтой байна. Коронавирусын үед тус асуудал зохимжгүй байгаа тул холбогдох байгууллагад уламжлан арга хэмжээ авч өгнө үү. Ялангуяа Баянзүрх болон Чингэлтэй дүүрэгт их шалгаж байна.	Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газрын даргаас замын хөдөлгөөнд оролцож байгаа иргэдийг тандагч багажаар үлээлгэхгүй байх талаар алба хаагчдад албан бичиг хүргүүлсэн тухай иргэн А.Отгондаваад хариу мэдэгдсэн.
3.	2022.01.17 07:58	126936	Хүсэлт	Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт 2021 оны 12 дугаар сарын 30-нд торгуулсан байх юм би энэ	Тээврийн цагдаагийн албанаас иргэн А.Мөнхбаттай 96663767 дугаарын утсаар

				өдөр хөдөө байсан юм. 65-89 ДУА Хундаа портер 2 бага оврын ачааны машин байгаа юм үүнийг шалгаж өгнө үү.	холбогдож, тээврийн хэрэгслийн улсын дугаар андуурагдсан талаар тайлбарлан өгч, Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, технологийн төвд улсын дугаарыг өөрчлүүлэх хүсэлтийг засварлуулахаар хүргүүлсэн.
4.	2022.01.04 13:41	122462	Хүсэлт	Тээврийн цагдаагийн албанд өргөдөл өгөөд асуудлыг шийдвэрлэж өгөхгүй байна, машины торгуулиа давхар төлсөн юм. Өргөдөл ямар шатандаа явж байгааг нь мэдмээр байна. Үүнийг цааш нь уламжилж өгнө үү.	Нийслэлийн төрийн сантай ташаарсан орлогын гүйлгээг засварлуулахаар холбогдсон талаар Тээврийн цагдаагийн албанаас иргэнд 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр холбогдож, хариу мэдэгдсэн.
5.	2022.01.10 15:42	124915	Гомдол	Баянгол цагдаагийн 1-р хэлтэс би хамт ажилладаг хүндээ дансаар мөнгө шилжүүлэн залилуулсан. Энэ талаар Баянгол цагдаагийн 1-р хэлтэс болон шүүхийн шийдвэрийн хэлтэст хандахад залилан биш гээд буцаасан. Дахин хандахад Баянгол цагдаагийн 1-р хэлтэс шүүхийн байгууллага 2 хоорондоо явуулаад огт шийдвэрлэж өгөхгүй байгаад гомдолтой байна. Одоог хүртэл хаягийг өгөхгүй байна. Цагдаагийн 1-р хэлтэст тус этгээдийн хаяг байгаад байхад Иргэний шүүх нь хаягийг олохгүй байна гэж хэлдэг. Иймд холбогдох байгууллагад уламжлан арга	Баянгол дүүрэг дэх цагдаагийн газрын 1 дүгээр хэлтсээс 26ё1-3/7345 дугаар албан бичгээр иргэн П.Өлзийбаярт хариу өгсөн болно.
6.	2022.02.11 14:59	134975	Талархал	Чингэлтэй дүүргийн 1-р хорооны цагдаагийн газрын Эргүүлийн офцер Найдан, ахлагч С. Анхбаяр нарт миний алдсан юмыг маань хурдан шуурхай олж өгсөнд талархаж ажилд нь амжилт хүсье.	Талархлыг алба хаагчдад хүргэж, ажлын амжилт хүсэв.
7.	2022.01.17 06:44	126903	Хүсэлт	Миний бие Бадарч овогтой Одхүү нь Одхүү Бадарч facebook хаягтай гэтэл зураг нэртэй хуурамч Бадарч Одохүү гэсэн хаяг нээсэн байна. Энэхүү хуурамч хаяг нь миний нэр дээр зургийг ашиглаж бусдын нэр хүнд залилан магадгүй хүний наймаа ёс зүйгүй үйлдэл хийж магадгүй гэж миний бие хардаж байна. Иймд энэхүү хуурамч хаягийг хэн, хаанаас ямар зорилгоор нээснийг тогтоож эзэн холбогдогчийг хуулийн хариуцлага хүлээгэн мөн хуурамч facebook хаягийг устгаж өгнө үү гэсэн хүсэлтэй	Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн газрын 1 дүгээр хэлтэс иргэний гомдолд шалгалтын ажиллагаа явуулж, Харилцаа холбооны зохицуулах хороонд хуурамч хаягийг устгуулахаар албан бичиг явуулсан талаар 26з1/1349 дугаар албан бичгээр иргэнд хариу мэдэгдсэн.
8.	2022.02.17 09:18	136572	Талархал	Манай ээж Зүүнхараагаас Сэлэнгийн воганаар ирж яваад замдаа бүх бичиг баримтаа алдаад Төмөр замын ахмад Нямдоржийн Бат гэдэг цагдаа олж өгсөнд талархаж байна. Үнэхээр мундаг сэтгэлтэй	Талархлыг алба хаагчдад хүргэж, ажлын амжилт хүсэв.

				ажилдаа сайн цагдаа байна. Талархалыг минь дамжуулж өгнө үү	
9.	2022.02.23 10:04	138694	Талархал	Би кибер гэмт хэрэгт холбогдоод байхад эрүүгийн мөрдөн байцаагч хошууч Энх-Амгаланд талархсанаа илэрхийлмээр байна. Миний асуудлыг хурдан шуурхай шалгаад шийдвэрлэж өгсөнд талархсанаа илэрхийлж байна.	Талархлыг алба хаагчдад хүргэж, ажлын амжилт хүсэв.
10.	2022.02.14 09:50	135151	Гомдол	Манай ах Хэнтий аймгийн цэнхэр мандал сумд 2022 оны 1 сарын 21 ны шөнө 6-лаа нийлээд ууж байгаад өнгөрсөн. Хүнд зодуулж алуулсан. Хэнтий аймгийн цагдаагийн газар 7-21 хоногийн хооронд шинжээчийн дүн гарна гээд байгаа, хамт байсан хүмүүс нь бие биенээ батлан даагаад суллалсан байна. Хэргийг удаашруулж байгаад гомдолтой байна. Энэ асуудлыг шалгаад надад яаралтай хариу хэлнэ үү.	Иргэний гомдлын дагуу Хэнтий аймаг дахь цагдаагийн газраас шалгалтын ажиллагаа явуулж, иргэнд 47/602 дугаар албан бичгээр хариу өгсөн болно.
11.	2022.01.27 15:35	131488	Хүсэлт	Авто машины албан татвараа 2022 оны 1 сарын 21-ний өдөр төлсөн юм гэтэл 1 сарын 23-нд замын цагдаа намайг зогсоогоод татвараа төлөөгүй байна гээд намайг 50,000 төгрөгөөр торгосон юм. Энэ ямар учиртай юм бэ е монголиа-аар төлбөрөө төлсөн шүү дээ. Үүнийг цааш нь уламжилж иргэнд яаралтай хариу өгнө үү.	Тээврийн цагдаагийн албанаас шалгалтын ажиллагаа явуулж иргэн Ц.Батбилэгт 14-1е/290 дугаар албан бичгээр хариу өгсөн болно.
12.	2022.02.08 07:33	133017	Гомдол	2022 оны 1 сарын 29-нд Дорнод аймагт машинаа мөргүүлсэн юм. Машин мөргөсөн хүн нь Дорнод аймгийн Прокурорын газрын зөрчлийн хяналтын прокурор хүн байгаа юм. Цагдаагийн байгууллагад хэлсэн арга хэмжээ авахгүй байна, Машин мөргөсөн хүний нэр Д.Батжаргал гэдэг хүн. 89-89 ДОУ энэ дээр арга хэмжээ авч өгнө үү. Гомдолтой байна.	Иргэний гомдлын дагуу Дорнод аймаг дахь цагдаагийн газраас цагдаагийн ахлах дэслэгч Ч.Улзад холбогдох албаны шалгалт явуулахад цагдаагийн алба хаагчийн буруутай үйлдэл тогдоогдсон тул сахилгын шийтгэл оногдуулж, энэ талаар иргэнд хариу мэдэгдсэн болно.
13.	2022.02.21 10:29	137679	Санал	Сайн байна уу? Согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэн нийгмийн хэв журмыг зөрчиж эрүүлжүүлэгдсэн иргэдэд Согтууруулах ундааны зохистой хэрэглээ ба хуулийн холбогдох сургалт оруулна уу.	Иргэний гомдлыг хүлээн авч, Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албанаас иргэн Г.Энхбаярт 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 01 хариу мэдэгдэх хуудас хүргүүлсэн байна.
14.	2022.03.02 13:45	141576	Талархал	13-ний шилжих шөнө таксинд дээрэмдүүлээд цагдаад бүртгүүлсэн. Тэгсэн хурдан шуурхай олж өгсөнд ХУД-ын 2-р хэлтэсийн ахлах дэслэгч Д. Тамжид гэдэр хүнд талархсанаа илэрхийлье. Ажилд нь амжилт хүсье	Талархлыг алба хаагчдад хүргэж, ажлын амжилт хүсэв.

15.	2022.02.09 07:56	133537	Хүсэлт	Торгуулийн мөнгийг намар 50 хувийг нь төлсөн шүү дээ гэтэл миний машины торгууль одоог хүртэл төлөгдөөгүй байх юм. Үүнийг холбогдох газарт нь уламжилж шалгаж өгнө үү.	Тээврийн цагдаагийн албанаас иргэний гомдлыг шалгахад иргэн Р.Ганхүү нь дансны дугаар андуурч торгуулийн төлбөрөө шилжүүлсэн байх тул энэ талаар тайлбар зөвлөгөө өгсөн болно.
16.	2022.02.14 07:52	135067	Гомдол	Хэнтий аймгийн цагдаагийн газартай холбоотой гомдол хэлмээр байна. 2017 онд гэрийнхээ гаднаас автомашинаа алдсан юм 74-74ХЭА түүнээс хойш Хэнтий аймгий цагдаагийн газар миний хэргийг үндэслэлгүйгээр хэрэгсэхгүй болгосон. 5 жил болж байхад ямар ч арга хэмжээ авахгүй байна. Хэнтий аймгийн цагдаагийн газрын мөрдөн байцаагчтай ярьсан чинь миний хэргийг мэдэхгүй байсан, доривтой ажиллагаа явуулж өгнө үү гэсэн гомдолтой байна. Холбогдох газарт нь уламжилж арга хэмжээ авч өгнө үү.	Хэнтий аймаг дахь цагдаагийн газраас иргэний гомдолд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа бөгөөд энэ талаар иргэн Г.Балжмаад 47/700 дугаар албан бичгээр хариу мэдэгдсэн болно
17.	2022.02.23 07:28	138545	Гомдол	Хүрээлэн буй орчины цагдаа Очирбаяр дээр гомдол гаргах гэсэн юм. Энэ хүн манай нөхөр өөр хүүхэнтэй нийлээд намайг элдэвээр гомдоосон. Надаас 1 сая төгрөг аваад авлига өгөөд багажаа авсан. Ажилын багаж авах гээд нэг хүнд авлига өгсөн. Тэр хүүхэн нь ЭХЭМҮТ-д эх баригч хийдэг. Намайг болон миний 10 настай охиныг элдэвээр хэлж байна. Би энэ цагдаагийн ёс зүйн асуудал дээр гомдол гаргамаар байна.	Иргэнийн гомдлын дагуу Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албанаас цагдаагийн ахлагч Б.Очбаярт холбогдох албаны шалгалт явуулахад иргэн А болон охиныг хэл амаар доромжилсон, бусдад авлига өгсөн гэх буруутай үйл ажиллагаа тогтоогдоогүй бөгөөд энэ талаар 13-6/700 дугаар албан бичгээр иргэнд хариу өгсөн болно.
18.	2022.03.28 13:44	149396	Талархал	ЦЕГ-ын Хар тамхитай тэмцэх газрын ахмад н.Зоригтбаатарт талархал илэрхийлмээр байна. ХУД-ийн 52-р сургуулийн 11-ээс 12-р ангийн хүүхдүүдийн эцэг эхэд "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийн нөхцөл байдал" сэдвээр сургалт хийж, хүүхдүүддээ энэ төрлийн гэмт хэргээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар үнэтэй зөвлөгөө өгсөнд баярлалаа. Өсвөр үеэ зөв, сайхан хүмүүжүүлэхэд эцэг, эхийн зайлшгүй мэдэж байх мэдлэг, мэдээллийг өгсөнд ахмад н.Зоригтбаатарт ажлын амжилт хүсэн ерөөе. Эцэг эхийн төлөөлөл.	Талархлыг алба хаагчдад хүргэж, ажлын амжилт хүсэв.
19.	2022.03.28 15:20	149493	Талархал	БГД 5-р хорооны 2-р хэлтсийн дэд ахлагч Билгүүдэй болон 1-р хэлтсийн ахлагч М.Эрдэнэбазар нарт хүүхдийн утсыг түргэн шуурхай олж өгсөнд чин сэтгэлээсээ талархал	Талархлыг алба хаагчдад хүргэж, ажлын амжилт хүсэв.

				илэрхийлж байна. Цаашдын ажилд нь амжилт хүсье.	
20.	2022.04.08 07:53	153740	Талархал	Шинэ нисэх буудлын цагдаагийн албан хаагч Б.Цогоо, дэд ахлагч Хатантамир, дэд ахлагч Тавууба нарт талархал илэрхийлж байна. Миний бие Шинэ нисэх буудал дээр утсаа алдаад, ямарч олох боломжгүй болсон байхад ур чадвараа гарган түргэн шуурхай олж өгсөнд талархаж байна. Ажилд нь амжилт хүсье.	Талархлыг алба хаагчдад хүргэж, ажлын амжилт хүсэв.
21.	2022.04.07 10:23	153190	Талархал	ХУД-ийн 6 дугаар хорооны дэслэгч н.Отгонбаатарт талархал илэрхийлмээ байна. 2022 оны 4 дүгээр сарын 4-нд өөрийн ажлын байран дээрээс гар утсаа хулгайд алдахад хувийн машинаараа үйлчилж, түргэн шуурхай ажиллаж, өргөсөн тангарагтаа үнэнчээр зүтгэж иргэн бидэнд тусалсанд маш их баярлалаа. Ажилд нь амжилт, амьдралд нь хамгийн сайхан бүхнийг хүсье.	Талархлыг алба хаагчдад хүргэж, ажлын амжилт хүсэв.
22.	2022.03.15 12:20	145759	Гомдол	Ховд аймгаас ярьж байна. Би өчигдөр билетээ бичүүлээд Ховд аймаг руу явсан юм гэтэл замдаа жолоочид нь зодуулаад надтай ёс зүйгүй харьцаад миний ачааг хээр буулгаад надтай ёс зүйгүй харьцаад намайг зодсон. Би маш их гомдолтой байна би Улаанбаатар хотод амьдардаг, намайг 4,5 цаг доромжилсон, би Ховд аймгийн цагдаагийн газарт гомдол гаргасан юм гэтэл намайг эсэргээр намайг манай ажил руу худлаа мэдээлэл мэдүүлсэн би маш их гомдолтой байна. Миний	Ховд аймаг дахь цагдаагийн газраас иргэнтэй холбогдож, хариу мэдэгдсэн болно.
23.	2022.04.01 14:15	151306	Гомдол	2022 оны 3 дугаар 26-нд E-Mongolia аппликейшнаар миний мэдээлэл алдагдаж Хаан банкны дансанд байсан 3,050,000₮ хулгайд алдагдсан. Мобиком үүрэн холбооны компаниас тодруулахад "E-Mongolia"-аар мэдээлэлээ алдсанаас болоод таны дансан дахь мөнгө алдагдсан байна гэж мэдэгдсэн. Ховд аймгийн цагдаагийн газарт мэдэгдсэн байгаа. Энэ асуудлыг холбогдох байгууллагад дамжуулж шийдвэрлэж өгнө үү.	Иргэний гомдлын дагуу шалгалтын ажиллагаа явуулахад иргэн Э 2022 оны 03 дугаар сарын 27-ны өдөр өөрийн биеэр Ховд аймаг дахь цагдаагийн газарт өргөдөл гаргасныг бүртгэлд оруулан эрүүгийн ахлах мөрдөгч, цагдаагийн ахлах дэслэгч Ц.Ариунбат мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа болно.
24.	2022.04.13 13:16	157592	Талархал	Цагдаагийн ерөнхий газрын эрүүгийн мөрдөгч И.Манлай нь мэргэжлийн ур чадвар гаргаж, маш богино хугацаанд хэргийг илрүүлж өгсөнд маш талархаж байна. Танд ажилд нь амжилт хүсэж, эрүүл энх сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.	Талархлыг алба хаагчдад хүргэж, ажлын амжилт хүсэв.

25.	2022.04.12 13:02	156487	Талархал	Цагдаагийн Ерөнхий газрын ахмад н.Бөхбат болон хамт олонд нь талархал илэрхийлье. Түргэн, шуурхай ажиллаж хүүгийн минь алдагдсан эд зүйлийг олж өгсөнд баярлаж байна. Цагдаагийн ерөнхий газрын нийт бие бүрэлдэхүүнд цаашдын ажилд нь амжилт хүсье	Талархлыг алба хаагчдад хүргэж, ажлын амжилт хүсэв.
26.	2022.04.11 12:46	155349	Талархал	ХУД-ийн нэгдүгээр хэлтсийн эргүүлийн цагдаа Түвшинжаргал, жолооч ахлагч Ариунбаяр нарт талархал илэрхийлмээр байна. Мэргэжлийн ур чадвар гаргаж, түргэн шуурхай үйлчилж, асуудлыг шийдвэрлэж өгсөнд талархаж байна.	Талархлыг алба хаагчдад хүргэж, ажлын амжилт хүсэв.
27.	2022.04.20 13:40	163139	Талархал	Чингэлтэй дүүргийн 2 хэсгийн цагдаагийн байцаагч О.Билгүүн болон хамт олонд нь талархал илэрхийлье. Мэргэжлийн ур чадвар гаргаж, түргэн шуурхай ажиллаж миний хүүгийн алдсан гар утсыг олж өгсөнд талархаж байна. Танд болон хамт олонд нь ажлын өндөр амжилт хүсье.	Талархлыг алба хаагчдад хүргэж, ажлын амжилт хүсэв.
28.	2022.03.23 20:06	148274	Санал	Сайн байна уу? Тээврийн цагдаагийн албанд санал хүргүүлж байна. Тээврийн цагдаагийн албанаас хэвлэл мэдээллийн хэрэгсэлд 200.000 төгрөгөөс дээш торгуультай хүн 48 ширхэг, 100.000-200.000 төгрөг хүртэл торгуультай хүн 1000 хүн, 50000-100.000 хүртэл 8000 хүн, 20.000-50000 торгуультай 70.000 хүн байгаа торгуулийн төлөлт бага хувьтай байгаа бөгөөд торгууль төлөгдөхгүй байгаа шалтгаан нь бэлэн бус төлөлт гэж ярьж байна. Бэлэн бус төлөлт нь авилга хүнд суртлыг арилгасан зөв зүйл ба авто машины	Монгол Улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1-д зааснаар замын хөдөлгөөнд оролцогч нь замын хөдөлгөөний дүрмийг баримтлан саадгүй зорчих эрхтэй юм. Монгол Улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 8.1, 8.2 дугаар зүйлд Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад цагдаагийн байгууллагын эрх үүргийг тодорхой зааж өгсөн байдаг бөгөөд тус хуулийн 8.1.2 дахь хэсэгт \"замын хөдөлгөөнд оролцогчийн хэвийн, аюулгүй зорчих нөхцлийг хангах зорилгоор замын хөдөлгөөнийг зохицуулах\", 8.2.2 дахь хэсэгт \"замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор замын хөдөлгөөнийг зохион байгуулах, урсгал, чиглэлийг түр өөрчлөх, хязгаарлах, хаах\", 8.2.4 дэх хэсэгт \"Холбогдох хуульд заасны дагуу Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага оногдуулах, зөрчлийн бүртгэлийн оноо тооцох эрхтэй\" гэж хуульчилж өгсний дагуу цагдаагийн ерөнхий газрын Тээврийн цагдаагийн албанаас хяналт шалгалтыг эрчимжүүлж, хяналт тавин ажиллаж байна. Тээврийн цагдаагийн алба нь эрх бүхий дээд байгууллагаас гаргасан тогтоол

					шийдвэрийг биелүүлэх үүрэг хүлээдэг бөгөөд иргэдийг аюулгүй, ая тухтай, түргэн шуурхай зорчуулахын төлөө ажиллаж, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаатай холбоотой хууль, тогтоомж, стандарт, тогтоол, захирамжийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавин ажиллаж байгаа болно. Энэ талаар иргэнтэй 8811 дугаарын утсаар холбогдож, хариу өгсөн.
29.	2022.04.08 12:06	154140	Гомдол	УБҮ-1659 дугаартай автомашины нэр дээр болон жолоодож явсан жолоочийн нэр дээр давхар торгууль гарч ирээд байна. Машины торгууль төлсөн боловч жолоочийн нэр дээр торгууль төлөгдөөгүй гэж гарч ирээд байгаа тул энэ асуудлыг холбогдох газарт уламжилж, шийдвэрлэж өгнө үү.	Иргэний гомдлын дагуу шалгахад 1659УБҮ улсын дугаартай автомашин дээр 3 торгууль байх бөгөөд иргэнтэй холбогдож асуухад миний машин дээр 3 торгууль байгаа төлөөгүй, миний тавьж байгаа асуудал бол автомашины торгуулийг жолооч болон машин дээр давхардаж бичиж байгаа нь хүндрэлтэй байна гэв. Иргэнд торгуулийн мэдээлэл давхардал биш нэг торгууль хоёр янзаар харагдаж байгаа талаар тайлбар, зөвлөмжийг 2022 оны 04 дүгээр сарын 14-ны өдөр 9110 дугаарын утсаар холбогдож өгсөн.
30.	2022.04.11 13:18	155419	Гомдол	Жин, тонн хэтэрсэн гээд хувь хүнийг 150000 төгрөгөөр торгох нь өндөр торгууль байна. Торгуулийг багасгах талаар арга хэмжээ авч өгнө үү.	Зөрчлийн тухай хуулийн 14.5.20 дахь хэсэгт зааснаар Авто зам, замын байгууламжаар зорчих, тээвэрлэлт хийхдээ стандарт, норм, дүрэм зөрчиж нэг тэнхлэг дээрх, эсхүл нийт жинг хэтрүүлсэн бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэх заалтыг иргэн Д.3-ийн 9511 дугаарын утсаар 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр 17 цаг 43 минутанд Тээврийн цагдаагийн албанаас холбогдон тайлбарлаж хариу мэдэгдсэн.
31.	2022.04.11 11:09	155247	Гомдол	Шатахуун тээврийн машиныг товчоон дээр жин тонн хэтрүүлсэн гэж 150.000 төгрөгөөр торгоод байх юм. Энэ асуудлыг холбогдох газарт нь уламжилж өгнө үү.	Зөрчлийн тухай хуулийн 14.5.20 дахь хэсэгт зааснаар Авто зам, замын байгууламжаар зорчих, тээвэрлэлт хийхдээ стандарт, норм, дүрэм зөрчиж нэг тэнхлэг дээрх, эсхүл нийт жинг хэтрүүлсэн бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх

					хэмжээний төгрөгөөр торгоно гэх хуулийн заалтыг Тээврийн цагдаагийн албанаас иргэн Ч.Р-ын 9811.... дугаарын утсаар 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр 17 цаг 46 минутанд холбогдон тайлбарлаж хариу мэдэгдсэн.
32.	2022.04.11 14:03	155544	Гомдол	Ачааны автомашины даац хэтэрсэн гээд цагдаа нар торгоод байна. Торгуулийн дүн өндөр байна. Цагдаа нарын карманд ордог нь бид бүхэнд гомдолтой байна. Энэ асуудлыг холбогдох байгууллага анхаарлаа хандуулж шалгаж, арга хэмжээ авч өгнө үү.	Зөрчлийн тухай хуулийн 14.5.20 дахь хэсэгт зааснаар Авто зам, замын байгууламжаар зорчих, тээвэрлэлт хийхдээ стандарт, норм, дүрэм зөрчиж нэг тэнхлэг дээрх, эсхүл нийт жинг хэтрүүлсэн бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэх хуулийн заалтыг Тээврийн цагдаагийн албанаас иргэн Д.Э-ын 8916.... дугаарын утсаар 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр 18 цаг 03 минутанд холбогдон тайлбарлаж хариу мэдэгдсэн.
33.	2022.04.11 10:24	155109	Гомдол	ЧД-ийн 17 дугаар хорооны ХБИ иргэн. Би машиндаа ХБИ-ийн шар наалттай бөгөөд нэгдүгээр эгнээгээр зорчих эрхтэй. Гэтэл замын торгууль ирээд байна. Энэ асуудлыг холбогдох газарт нь уламжилж, шийдвэрлэж өгнө үү.	Иргэн Т.Д-д Замын хөдөлгөөний Удирдлагын төвийн дарга С.Адъяасүрэнд хөгжлийн бэрхшээлтэй иргэний шар наалтаар замын хөдөлгөөнд оролцох хүсэлтийг гаргаж, өөрийн автомашиныг бүртгэлжүүлэх талаар зөвлөгөөг өгсөн. Тухайн иргэн нь "Хөгжлийн бэрхшээл"-тэй иргэний автомашинд олгодог шар наалтыг Замын хөдөлгөөний удирдлагын төвд бүртгүүлээгүй байсан тул камерийн торгууль ирсэн байна. Энэ талаар 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр 17 цаг 29 минутанд иргэн Т.Д-ийн 9914... дугаарын утсаар холбогдож хариу мэдэгдсэн.
34.	2022.04.11 12:57	155372	Гомдол	2009 оноос Швед улсад амьдарч байгаа. Гэтэл миний жолооны үнэмлэхийг өөр хүн ашиглаад торгуулиад байх юм. 2017 оноос эхэлсэн торгуулийн мэдээлэл E-Mongolia дээр ирээд байна. Жолооны үнэмлэхний дугаар: 48056 . Энэ асуудлыг холбогдох газарт нь уламжилж, шийдвэрлэж өгнө үү.	Иргэн Ч.Л-ынн 48056 дугаартай жолооны үнэмлэхээр 2018 оны 11 дүгээр сарын 06, 2019 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр тус тус Өмнөговь Ханбогд 01 баг Номгон 17-1 тоотод хаягтай ОМОГТ ЦАГААН ШОНХОР ТРАНС ХХК-ний 06-73 ӨМӨ улсын дугаартай Foton BJ4253 маркийн автомашины жолооч торгуульсан байв. Гомдол, мэдээллийг хүлээн авсан талаар иргэнд 7270.... дугаарын утсаар 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр 17 цаг 33 минутанд хариу мэдэгдсэн бөгөөд шалгалтын ажиллагааг үргэлжлүүлж байна.

35.	2022.04.12 10:04	156176	Гомдол	2022 оны 4 дүгээр сарын 8-ны шөнө манай байрны гараашийн хаалга эвдрээд засвартай байсан тул гараашийн хаалга хаагаад автомашинаа байрлуулаад үлдээсэн. Гэтэл надад шөнийн 00 цагт явган хүний зам дээр тавьсан байна гээд торгууль ирсэн байна. Тэр нь явган хүний зам огт биш юм. Эзэн хаяггүй энэ торгуулиа болимоор байна. Энэ асуудлыг холбогдох байгууллагад нь уламжлан иргэнд яаралтай хариу өгнө үү. Иргэнтэй холбогдох	Иргэн С.Батцэнгэлээс гаргасан гомдол, мэдээллийг шалгахад 2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр Баянзүрх дүүргийн 14-р хороо 53А байрны гражийн үүдэнд оршин суугчдын зорчих хэсгийг хааж автомашинаа байрлуулсан байсан тул оршин суугчдаас Баянзүрх дүүрэг дэх Замын цагдаагийн хэлтэст дуудлага, мэдээлэл өгч жолоочид нь арга хэмжээ тооцуулсан байна. Энэ талаар Тээврийн цагдаагийн албанаас иргэн С.Батцэнгэлд 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр 18 цаг 03 минутанд 8693.... дугаарын утсаар холбогдож хариу мэдэгдсэн.
36.	2022.04.07 09:37	153099	Тодорхойгүй	Миний бие 2022.01.21-ний өдөр Тээврийн цагдаагийн албанд "Бэлэн бус торгуулийн талаар гомдол гаргах тухай" гомдол гаргасан. \nГомдлын агуулга: Миний бие Пүрэвсүрэнгийн Батбаяр /НЮ84120178/ нь 9983 УБН улсын дугаартай Nissan X.Trial маркийн /эхнэр Ч.Үүрийнтуяа "УЕ85122307"-гийн нэр дээр байдаг/ автомашин эзэмшдэг. \n 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдөр 16 цаг 06 минутад Улаанбаатар хот Хан-Уул дүүрэгт ажил дээрээ байхад 88087442 дугаарын утаснаас "Төв аймгийн Сүмбэр сумын хэсгийн төлөөлөгч байна, манай сумын цагдаа	Иргэн П.Батбаярын гомдлын дагуу Тээврийн цагдаагийн албанаас шалгалтын ажиллагаа явуулж, буруутай иргэний торгууль төлсөн банкны хуулгыг "\"Торгууль.мн\""-д төлсөн бүртгэлд оруулж, энэ талаар иргэн П.Батбаяртай 8997.... дугаарын утсаар холбогдож хариу мэдэгдсэн.
37.	2022.04.12 16:03	156936	Гомдол	Иргэн хүн жагсаал цуглаанд оролцож үгээ хэлэх эрхтэй шүү дээ. Эрүүгийн цагдаагийн албаны ажилтан Э.Даваадорж /99259971/ гэж хүн залгаад: Танай нөхөр жагсаалд оролцсон уу? гээд асууж шалгаагаад байх юм. Хувийн мэдээлэл бүх зүйлийг мэдэж байна. Жагсаалд оролцсон байсан ч цагдаад байцаагдах ёсгүй гэж бодож байна. Энэ асуудлыг холбогдох газар нь уламжилж өгнө үү.	Иргэний гомдолд Эрүүгийн цагдаагийн албанаас шалгалтын ажиллагаа явуулахад цагдаагийн алба хаагчийн буруутай үйл ажиллагаа тогтоогдоогүй талаар 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 11а/3154 дүгээр албан бичгээр иргэн Т.А-д хариу өгсөн.
38.	2022.04.06 14:20	152700	Гомдол	2019 оны 12 дугаар сард Амгаланд байрлах авто тээврийн үндэсний төвийн салбараас 8631УНУ улсын дугаарыг авсан. Өршөөлийн хуулийн дагуу торгуулийн хөнгөлөлтөд хамрагдаж 500,000 гаруй төгрөг төлсөн. Торгуулиа төлсний дараа автомашины улсын дугаараар шүүхэд 8631УНУ улсын дугаар нь "\"HOWO\" маркийн хүнд машин, эзэмшигч нь Сайнхишигийн Эрдэнэсаруул нэрээр гарсан. Миний зүгээс 370,000 төгрөг илүү төлсөн	Иргэний гомдол нь Авто тээврийн үндэсний төвд хандахад шийдвэрлэж өгөөгүй гомдол байсан. Иргэнд учирсан хохирлын талаар Авто тээврийн үндэсний төвийн холбогдох албан тушаалтаннаас тодруулахад тухайн улсын дугаарыг урд эзэмшигч иргэний торгуулийг шилжүүлсэн байсан тул 362.500 төгрөгийн торгуулийг буцаан олгуулахаар холбогдох материалыг Санхүү, аж ахуйн тасагт

				тул авто тээврийн үндэсний төв, замын цагдаагийн газруудад санал хүсэлт гаргасан боловч шийдвэрлэж өгөхгүй удлаа. Иймд	шилжүүлэн шийдвэрлсэн талаар 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр иргэн Х.Б-д хариу өгсөн.
39.	2022.04.26 13:59	167240	Талархал	Замын цагдаа ахлагч Н.Цэнд-Аюушид талархал илэрхийлье. Хүний төлөө гэсэн сэтгэлтэй, тусч зантай, эелдэг найрсаг харилцаатай танд ажилд нь амжилт хүсэж, амьдралд нь эрүүл энх сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.	Талархлыг алба хаагчдад хүргэж, ажлын амжилт хүсэв.
40.	2022.04.18 11:14	160306	Гомдол	Замын цагдаагийн газарт гомдол гаргамаар байна.Би автомашины торгуулийг төлсөн боловч торгууль нь төлөгдөөгүй гэж харагдаж байна. Замын цагдаагийн газрын лавлах утас холбогдсон боловч утсаа огт авахгүй байна. Миний асуудлыг холбогдох байгууллагад уламжилж өгнө үү.	Иргэний гомдлыг шалгахад 3786ХӨВ улсын дугаартай автомашин дээр 2016 оны 09 дүгээр сарын 19-ны өдөр Булган аймгийн нутаг дэвсгэрт 96000 төгрөгөөр торгуулсан төлбөрийн мэдээлэл байна. Уг торгууль нь Нийслэлийн төрийн сангаас гарах боломжгүй тул иргэн Д.Мандахнямд Булган аймгийн төрийн сангаас торгууль төлсөн хуулбарыг авч Torguuli.mn@gmail.com гэсэн хаягт илгээж хасалт хийлгэх боломжтой талаар 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр 8016.... дугаарын утсаар холбогдож, хариу мэдэгдсэн.
41.	2022.04.18 17:12	160993	Гомдол	Дугаарын хязгаарлалтай өдөр гарч яваад 2 удаа торгуульчихсан юм. Асуухаар 10 ч удаа торгож болдог гэх юм. 1 удаа торгоод явуулах дүрэм, журам байхгүй юу гэсэнд манай нийслэлийн засаг даргын захирамжаар тийм дүрэм байхгүй ээ гэж цагдаагаас хэлж байна. Нийслэлийн засаг даргын тамгын газар, Тээврийн цагдаа 2-ыг яагаад холбож ажиллуулаад байгаа юм бэ. Нийслэл нь нийслэлээ, тээврийн цагдаа нь замаа мэдэж ажиллах хэрэгтэй. Гэтэл тээврийн цагдаа нар нийслэлэд мөнгө	Иргэн Т.Отгонбаяртай 2022.04.22-ны өдөр 9903.... дугаарын утсаар холбогдож Зөрчлийн тухай хуулийн 1.3 зөрчил тус бүрд шийтгэл оногдуулна, 2020 оны А/1037 дугаартай Нийслэлийн засаг даргын захирамжийн дагуу “Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газар хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулан, зөрчлийг холбогдох хуульд заасны дагуу шийдвэрлэн ажиллаж байгаа талаар хариу өгсөн.
42.	2022.04.19 16:40	162359	Хүсэлт	Сайн байна уу. Юуны өмнө замын хөдөлгөөний дүрмийн хэрэгжилтийг хангуулан, идэвх зүтгэлтэй ажиллаж байгаа Тээврийн цагдаагийн хамт олонд ажлын амжилт хүсье. Миний бие нь 2019-11-24-ний өдөр өөрийн эзэмшлийн 6711УНХ прадо-120 маркийн автомашинтай Хан-Уул дүүргийн БХТН-ийн урд уулзвар дээр явж байгаад осол гаргасан. Тухайн үед н.Батбаяр ахмад (нэрийг нь сайн санахгүй байна) бичиг баримтыг хурааж аваад, хэрэг үүсгэн 100 000 төгрөгөөр торгосон. Дээрх осол гаргасан өдрөөс	Тээврийн цагдаагийн албанаас иргэн М.Пүрэвдоржтой 2022.04.22-ны өдөр 9190.... дугаарын утсаар холбогдож торгуулийн баримт цагдаагийн байгууллагад хадгалагддаггүй тул тушаасан банкнаас хуулга авч торгуулийг хаалгах боломжтой талаар хариу мэдэгдсэн.

43.	2022.04.19 10:40	161358	Гомдол	4 дүгээр сарын 8ны өдөр тээврийн хэрэгсэлтэй хөдөлгөөнд оролцоогүй байхад \"Сонгино-Хайрхан дүүрэг\"-н авто сургуулийн уулзвар гэдэг газар хөдөлгөөнд оролцсон байна гээд 10000 төгрөгний торгууль надад бичигдсэн байна. \"Тээврийн цагдаагийн газар\"-тай холбогдож \"андуурсан юм шиг байна\" гэж хэлэхээр та заавал ирж уулз гээд байгаа. Камер дээр бол таны автомашин харагдаагүй байна. Ахлах ахлагч Батзаяа тань дээр торгууль бичсэн байна энэ хүнтэй ирж уулз гэсэн. Миний хувьд биечлэн уулзах боломжгүй байгаа. Уг	СХД дэх ЗЦХ-ийн цагдаа зохицуулагч, цагдаагийн ахлах ахлагч Н.Батзаяа нь Б.Ганжигүүрийг Зөрчлийн тухай хуулийн 14.7.37 дахь заалтаар торгох үед нь багажны сүлжээ гацаж тээврийн хэрэгслийг андуурч торгосон байх тул торгуулийн мэдээллийн санд 9966 УАА дугаартай автомашиныг 5427 СБА дугаартай автомашин болгон залруулсан талаар иргэн Д.Амарсанаад 2022.04.26-ны өдөр 8001.... дугаартай утсаар мэдэгдсэн болно.
44.	2022.03.30 10:06	150291	Санал	Автомашины урд салхины шил дээр тень наах тухай, Улаанбаатар хотын автомашины тоо өдрөөс өдөрт нэмэгдэж байгааг та бүхэн мэдэж байгаа. Энэ дотроос урд салхины шилэн дээр тень наасан автомашины тоо сүүлийн үед маш эрчимтэй нэмэгдэх боллоо. Зөвхөн Чингисийн өргөн чөлөө, Энхтайваны гүүр хойноос урагш гүүр даваад явж байхад, эсрэг талын (урдаас хойш чиглэлд) түгжирч байгаа автомашинуудыг харахад л урд салхины шилэн дээр тень наасан тохиолдол маш олон байна.	Монгол Улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Замын хөдөлгөөний дүрмийн хэрэгжилт, тээврийн хэрэгслийн бүхээгний шилэн дээр наасан өнгөт хальс, тенийг Замын хөдөлгөөний дүрмийн 4 дүгээр хавсралтын 6.6.-д заасан заалтын шаардлагад нийцэж байгаа эсэхийг шалгаж, зөрчлийг арилгуулах талаар харьяа нэгжийн дарга нарт 2022.04.08-ны өдрийн 14-1/535 албан тоотоор хугацаатай үүрэг чиглэл өгсөн. Энэ талаар иргэн П.Ариунболдод 2022.04.12-ны өдрийн 14-1д/551 дугаартай албан бичгээр хариу өгсөн болно.
45.	2022.03.29 12:28	149914	Хүсэлт	"Цагдаагийн ерөнхий газар эрэн сурвалжиж байна" гэсэн зар фэйсбүүкэд яваад байна.Цагдаагийн ерөнхий газраас хохирогч, гэрчийн мэдээллийг дэлгэрэнгүй олон нийтийн сүлжээгээр мэдээллэж байна. Гэрч, хохирогчийн мэдээллийг нууцлах хэрэгтэй. Энэ хүсэлтийг зохих байгууллага руу уламжилж өгнө үү.	Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албанаас шалгалтын ажиллагаа явуулж, 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 11ж/2645 дугаар албан бичгээр иргэн М.Х-д хариу өгсөн.
46.	2022.03.30 14:26	150485	Гомдол	Цагдаагийн ерөнхий газрын бүртгэл хяналтын төвийн лицензийн шалгалт авах цагийг 12:00 цагаас хойш авахуулах хүсэлтэй байна. Үдээс хойш очиход шалгалт авах цаг дууссан гээд иргэдэд хүндрэлтэй байна. Энэ асуудлыг холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлэж өгнө үү.	Иргэний гомдлыг судалж үзэхэд Цагдаагийн ерөнхий газрын Бүртгэл хяналтын төвөөс тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн замын хөдөлгөөний хууль, дүрмийн шалгалтын хуваарийг өмнөх өдөр нь гаргаж, "Бүртгэл хяналтын төв" нээлттэй фэйсбүүк хуудсанд байршуулж, сургалтын байгууллага, шалгуулагчдад мэдэгдэн ажлын өдрийн 08:30-17:30 цагт тогтмол 250-280 шалгуулагчаас шалгалтыг авч, ачаалалтай ажилладаг тул 12:00 цагаас хойш авах боломжгүй тул энэ

					талаар 8905.... дугаарын утсаар холбогдож, иргэн Т.Сарангэрэлд тайлбарлаж өгсөн.
47.	2022.04.19 11:10	161453	Гомдол	Дархан-Уул аймагт онц ноцтой гэмт хэрэг гарсан байна. МАН НАМЗХ-ны ой тэмдэглэсэн байна. Хэдэн өдрийн өмнө Хонгор суманд байрлах "Гүнж ресорт" дээр нэлээд олон хүн 100 жилийн ой тэмдэглэсэн. Засаг даргын орлогч НАМЗХ-ны тэргүүн Жавхлан архидан согтуурч гэр бүлийнхээ хүнийг машинаараа мөргөсөн байна. Тэр эмэгтэй Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлэгт ухаангүй сэхээнд байгаа юм. Хэрэг үйлдсэн Жавхланг Цагдаагийн газар саатуулсан ч удалгүй сулласан байна. Тухайн ойд оролцон архидан согтуурсан төрийн албан	Цагдаагийн ерөнхий газрын аюулгүй байдлын хэлтсээс хянан үзээд 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 36/3602 дугаар албан бичгээр иргэн П.Б-д хариу өгсөн.
48.	2022.04.01 11:37	151231	Гомдол	Гомдол яаралтай шийдвэрлэнэ үү. Өмнө гаргасан гомдлыг шийдэхгүй удаад байна. Иргэн Д овогтой Ц би 0003УБӨ улсын дугаартай Toyota Ландкрузер 105 маркийн Хар хөх өнгийн автомашиныг 2009 оноос эзэмшиж ашиглаж байна. 2022 оны 03 сарын 18, 03 сарын 24-ны өдрүүдэд Улаанбаатар хотод замын хөдөлгөөнд оролцож зөрчил гаргасан торгуулийн мэдээлэл мсж-ээр 2 удаа ирлээ.Би Өмнөговь аймагт машинтайгаа хөдөө байсан цаг хугацаанд гарсан зөрчил бөгөөд мэдээллийн баримтыг шалгаж үзэхэд миний машины номерийг	Тээврийн цагдаагийн албанаас иргэнтэй холбогдож, хариу мэдээлэл өгсөн болно.
49.	2022.04.05 08:19	151868	Санал	Жуулчны улирал эхлэх үеэр автобус дүүрэн солонгос эрэгтэй жуулчид ихээр ирдэг. Эмэгтэй жуулчид байдаггүй. Зочид буудлаар дүүрэн Монгол охид байрлаж, биеэ үнэлэлт явагдаж байгаа гэж хардаж байна.. Зочид буудалд буухад нь Солонгос жуулчдыг хяналтандаа авч баймаар байна. Энэ асуудлыг цагдаагийн байгууллагаар хянуулж, холбогдох газрууд авч арга хэмжээ авч өгнө үү.	Иргэний саналын дагуу Эрүүгийн цагдаагийн албанаас шалгалтын ажиллагаа явуулахад биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийн шинжгүй байна. Саналын дагуу холбогдох газруудад хяналт тавин ажиллах болно. Энэ талаар иргэн Оюунчимэгтэй 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр 9808.... дугаарын утсаар холбогдож, хариу мэдэгдсэн болно.
50.	2022.04.19 12:17	161628	Гомдол	Миний хамтран амьдрагч 2020 оны 12 дугаар сард цагдаагийн байгууллагад гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэний улмаас хэрэг үүсч шалгагдаж байх явцдаа гэм буруугаа өөрөө хүлээж 7 дугаар сарын 6-нд өршөөлийн хуулиар суллагдсан. Гэтэл хүчирхийлэл үйлдсэн хүн одоог хүртэл цагдаагийн албанд ажиллаад, ажил мэргэжлээ ашиглаад хүний хувийн мэдээлэл шалгадаг, хилийн хориг тавиулна гэж байнга дарамталж сүрдүүлдэг. Сонгино	Цагдаагийн ерөнхий газрын Аюулгүй байдлын хэлтсээс 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 36/3635 дугаар албан бичгээр иргэн Х.У-д хариу өгсөн.

				хайрхан дүүргийн цагдаагийн 2 дугаар хэлтэсийн даргад нь гомдол гаргасан боловч хэл үгээр дайрч	
51.	2022.04.21 08:44	163800	Санал	Цагдаагийн эргүүлийн машинууд хар tentэй байна. Цагдаагийн машин хар tentэй байх дүрэм журам бий юу? Иргэдийг хамгаалах үүрэгтэй хамгаалалтын машин дотор хэн байгаа, хэнийг хамгаалж байгаа нь ил байх ёстой учир үүнийг анхааралдаа авч холбогдох газар нь уламжилж өгнө үү.	Монгол Улсын Үндсэн хууль, Цагдаагийн албаны тухай, Гэрч хохирогчийг хамгаалах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль болон бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, "гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно" гэсэн зарчмыг баримтлан хүний нэр төр, алдар хүнд, хувь хүний мэдээллийг хамгаалах, гэрч хохирогчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор албаны автомашины доторх үзэгдэх орчныг хязгаарладаг талаар Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албанаас 13-6/1195 дугаар албан бичгээр иргэн Р.Б-д хариу өгсөн.
52.	2022.04.07 12:47	153343	Гомдол	Сэлэнгэ аймгийн цагдаагийн газарт гомдол гаргамаар байна. 3 дугаар сарын 31-ний өдөр бусдад зодуулж хүнд гэмтсэн. Цагдаа дуудсан боловч тухайн хүний хүү нь дэслэгч н.Амгаланбаатар нь ирээд хэл амаар доромжлон аавыгаа аваад бараг зугтаад явсан. Дахин дуудлага өгөхөд дэслэгч н.Дөлгөөн ирээд болсон зүйлийг бичлэг хийж авсан.Энэ хугацаанд надтай ямар ч хүн холбогдоогүй, шүүх эмч томилно гэсэн ямар ч хариу өгөөгүй ба 4 дүгээр сарын 4-ний өдөр тухайн үед авсан гэмтэлээс	Сэлэнгэ аймаг дахь цагдаагийн газраас мөн газрын алба хаагч, цагдаагийн дэслэгч Ч.Амарбаясгаланд холдох албаны шалгалт явуулахад цагдаагийн алба хаагчийн буруутай үйлдэл тогтоогдоогүй бөгөөд энэ талаар 42/1-1766 дугаар албан бичгээр иргэн Э.Б-д хариу мэдэгдсэн.
53.	2022.04.28 16:50	169411	Санал	Замын цагдаа нар барилгын том автомашиныг торгоод байна. Шөнө 22 цагаас хойш зуурмаг, бетон хийж болохгүй, өдрийн цагаар төв замаар явуулахгүй. Энэ хуулийг батлахдаа энэ талаар бодолцох хэрэгтэй байгаад байна. Замаа зохицуулалт хийхийн оронд торгоод байгаад байх юм. Энэ асуудлыг холбогдох байгууллагад нь уламжлан шийдвэрлэж өгнө үү.(Бичлэг сонсох)	Тээврийн цагдаагийн албанаас 2022 оны 05-р сарын 02-ны өдрийн 14-1д/675 дугаар албан бичгээр иргэн Б.Б-д хариу өгсөн.
54.	2022.04.13 17:27	157954	Гомдол	Эгнээ байр солих төдийд л чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээгээр явсан гээд торгоод байна. Урд нь бас хэд хэдэн удаа торгууль ирснийг би төлөөд л байсан. Энэ удаад үнэхээр гомдолтой	Иргэний гомдлын дагуу Тээврийн цагдаагийн албанаас шалгалтын ажиллагаа явуулж, 14-1в/383 дугаар албан бичгээр иргэн Б.Нямтогоод хариу мэдэгдсэн байна.

				байна. Холбогдох байгууллагад нь уламжлан шийдэж өгнө үү.	
55.	2022.04.27 14:54	168309	Гомдол	2022 оны 1 дүгээр сарын 27-нд Ленин клубын замаар 1 дүгээр эгнээгээр 22:45 цагт зорчиж явахад торгууль ирсэн. 2022 оны 4 дүгээр сарын 25-нд замын цагдаа зураг аваад явж байсан. Би бусад тээврийн хэрэгсэлд саад учруулаагүй байхад дахин торгууль ирсэн. Зөрчил гаргаагүй байхад гэнэт торгууль ирж байгаад бухимдалтай байна. Энэ асуудлыг холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлэж өгнө үү.	Тээврийн цагдаагийн албанаас 2022.05.04-ний 14-1в/408 албан бичгээр хариу өгсөн.
56.	2022.04.14 12:32	158379	Гомдол	Чингэлтэй дүүргийн 3 дугаар хороо "Олонлог" сургуулийн үүдэнд машинаа тавихаар торгоод байна. Замын хөдөлгөөнд саад учруулахгүй газар байршуулаад байхад ийм асуудал үүсээд байна. Энэ асуудлыг холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлэж өгнө үү.	Иргэний гомдлыг шалгаж, Чингэлтэй дүүрэг дэх цагдаагийн газраас 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 26л-3/159 дүгээр албан бичгээр иргэн Д.Оджаргалд хариу мэдэгдсэн байна.
57.	2022.04.12 16:27	156948	Гомдол	Хууль хэрэгжүүлдэг байгууллагууд хуулиа хэрэгжүүлэхгүй байна. Ялангуяа тээврийн цагдаагийн алба. Хуульд 24 цаг ажилласан бол амрах ёстой. Гэтэл дахиад 24 цаг ажиллуулж байна. Эсвэл 24 цаг хэсэг дээр ажиллуулчаад маргааш нь буулгачихаад нөгөөдөр нь дуудаж өдрийн 8 цагаар ажиллуулж байна. Залуучууд ажил хийхгүй байна гээд л байх юм. Ийм нөхцөлд яаж ажиллах вэ? Ийм бага цалин, дарамтад ажиллах хүн олдохгүй. Цагдаагийн албан хаагчтай холбоотой олон хэрэг гардаг ч нуун	Хан-Уул дүүрэг дэх цагдаагийн газраас шалгалтын ажиллагаа явуулж, 2022 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 26к/847 дугаар албан бичгээр иргэн Ц.Батсүхэд хариу өгсөн байна.
58.	2022.04.22 08:35	164780	Гомдол	Тэмээтэй хөшөөнөөс зүүн тийшээ давхар эргээд торгуулсанд гомдолтой байна. Автобусны асуудлыг шийдэхгүй бол эгнээ байраа зөв эзлээгүй 3 эгнээ зам хааж зогсоод зөрчил үүсгээд байна. Үүнээс болоод автобус дагаад давхар эргэсэн боловч иргэнээ торгоод байгаа асуудал үүсээд байна. Энэ асуудлыг холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлэж өгнө үү.	Иргэний гомдлыг Хан-Уул дүүрэг дэх цагдаагийн газрын Замын цагдаагийн хэлтсээс шалгаж, 2022 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 26к-3/409 дүгээр албан бичгээр иргэн Г.Шижирбаатарт хариу өгсөн болно.
59.	2022.04.26 15:16	167418	Гомдол	Говь-Алтай аймгийн иргэн байна. 2021 оны 09 дүгээр сарын 1-ний өдөр миний ажлын байранд хулгай ороод 115 гаран сая төгрөгөөр хохирсон. Тухайн хэрэгтнийг нь хотоос барьж ирсэн гэж байцаагч нь хэлж байсан ч одоо миний хэргийг Дорноговь аймгийн хүмүүс учир тухайн аймаг руу нь	Иргэний гомдолд дурьдсан хэргийг Улсын ерөнхий Прокурорын газраас харьяалал тогтоож, Говь-Алтай аймаг дахь цагдаагийн газраас Дорноговь аймаг дахь цагдаагийн газарт эрүүгийн хэргийг шилжүүлэн мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа бөгөөд энэ

				шилжүүлээ гэсэн. Уг нь хэрэгтэн нь баригдчихсан байхад миний хэргийг шуурхай шийдээд хохиролыг барагдуулах боломжтой баймаар юм. Энэ асуудлыг холбогдох байгууллагад нь уламжилж хохирлыг минь	талаар иргэн Я.Нарангэрэлд хариу мэдэгдсэн болно.
60.	2022.05.10 03:48	176634	Гомдол	Говь-Алтай аймгийн иргэн байна. 2021 оны 09 дүгээр сарын 1-ний өдөр миний ажлын байранд хулгай ороод 115 гаруй сая төгрөгөөр хохирсон. Энэ асуудлаар өмнө нь гомдол гаргахад Говь-Алтай аймгийн Цагдаагийн газарт шилжүүлээ гэсэн хариу өгсөн. Тухайн хулгайч нар нь Дорноговь аймгийн харьяатай тул тус аймаг руу шилжүүлээ гэсэн. Дорноговь аймгийн Цагдаагийн газрын 89388787 дугаартай байцаагч нь Улсын мөрдөн байцаах руу шилжүүлнэ гэж хэлээд өөр мэдээлэл өгөхгүй одоо утсаа ч авахгүй	Иргэний гомдолд дурьдсан хэргийг Улсын ерөнхий Прокурорын газраас харьяалал тогтоож, Говь-Алтай аймаг дахь цагдаагийн газраас Дорноговь аймаг дахь цагдаагийн газарт эрүүгийн хэргийг шилжүүлэн мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа бөгөөд энэ талаар иргэн Я.Нарангэрэлд хариу мэдэгдсэн болно.
61.	2022.04.14 15:42	158732	Гомдол	Сонгинохайрхан дүүргийн замын цагдаагийн ажилтнууд өглөө, орой бүр автомашинуудыг зогсоож жолооч нарыг үлээлгэж байна. Ковидын тухай хуулийг сунгасан байхад амнаас ам дамжуулан үлээлгэж байгаад гомдол гаргаж байна. Ковид 19 вирусээр өвдөх эрсдэл үүсгээд байна шүү дээ. Гомдлыг минь холбогдох байгууллагад уламжилж өгнө үү.	Харьяаллын дагуу Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн газрын Замын цагдаагийн хэлтсээс шалгалтын ажиллагаа явуулахад цагдаагийн алба хаагчийн буруутай үйл ажиллагаа тогтоогдоогүй талаар 2022 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн 263-4/386 дугаар албан бичгээр иргэн Г.Төгөлдөрт хариу өгсөн болно.
62.	2022.05.02 09:55	170647	Гомдол	Торгуулийн төлөлттэй холбоотой асуудлаар \"Тээврийн цагдаагийн алба\"-наас лавлагаа, мэдээлэл авах утас - 70191319 дугаараас лавлагаа авах гэтэл хүнд суртал гаргаад ярьж, асууж дуусаагүй байхад хариулахгүй шууд таслаад байна. Миний нэр дээр төлбөр гарсан байгааг лавлаж машины дугаарыг мэдэх гэтэл хэлэхгүй тасаллаа. Иргэний 99235700 дугаараар холбогдож хариу өгнө үү.	Тээврийн цагдаагийн албанаас иргэний гомдлыг шалгаж, 2022 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн 146/1266 дугаар албан бичгээр иргэн А.Б-д хариу мэдэгдсэн болно.
63.	2022.05.02 10:30	170723	Гомдол	2022 оны 03 дугаар сарын 8 нд бүх нийтийн амралтын өдрөөр 1 нэгдүгээр эгнээгээр явсан учраас надад торгууль ирсэн. Замын цагдаа руу залгаж амралтын өдөр байсан тул яагаад торгууль ирсэн вэ гэж лавлахад тус газраас нийтийн тээвэр явж л байгаа бол торгуулна гэж хариу өгсөн. Энэ асуудлыг тодруулж өгнө үү.	Тээврийн цагдаагийн албанаас шалгалтын ажиллагаа явуулж, 2022 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн 146/1265 дугаар албан бичгээр иргэн Ц.Бямбажавд хариу өгсөн болно.

64.	2022.04.25 09:44	165858	Гомдол	Би Дархан-Уул аймагт мод модон материалын бизнес эрхэлдэг. 2021.12.05-06 ныг шилжих шөнө 22-ын товчооны постоор Улаанбаатар хот руу нэвтрэх үед мэргэжлийн хяналтын байцаагч саатуулан цагдаагийн албан хаагч нь 10-20 хоног машин журмын хашаанд хийж хүндрэл бэрхшээл учруулж байгаад гомдолтой байна. 3 удаа ийм хүндрэл учруулж байгаад гомдолтой байна. Цагдаагийн албан хаагчаас лавлахаар бид шалгах эрхтэй, нэг бол мэргэжлийн хяналтаас саатуул гэсэн гэж хэлдэг. Гарал үсгийн бичгийг зарлагын баримтын хамт тээвэрлэнэ	Дархан-Уул аймаг дахь цагдаагий газраас иргэний гомдлын дагуу шалгалтын ажиллагаа явуулж, хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналтай прокурорт шилжүүлэн иргэн Д.Отгонсүрэнд хариу мэдэгдэх хуудсаар хариу өгсөн.
65.	2022.05.06 15:44	175104	Гомдол	Сэлэнгэ аймгаас Улаанбаатар хот руу явах замд Дархан аймгийн цагдаагийн постон дээр хурд хэтрүүлсэн гээд 50,000 төгрөгөөр торгуулсан гэж мэдэгдэл ирсэн. Цагдаа нар хүний эрхийг маш ихээр зөрчиж байна. Хурд хэтрүүлсэн гээд иргэнийг хэн дуртай нь торгож байна. Хүнийг дарангуйлж ингэж торгож байгаад гомдолтой байна. Энэ асуудлыг холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлэж өгнө үү.	Дархан-Уул аймаг дахь цагдаагийн газраас шалгалтын ажиллагаа явуулж, иргэн А.Баатаржаваас тайлбар авахад "Миний бие орчин үеийн техник хэрэгсэл нь хуучны тээврийн хэрэгсэлтэй адилгүй учир замын хөдөлгөөнд оролцох хурдны хязгаарын дээд хэмжээг 100 км/ц болгох талаар санал хэлсэн" гэв. Мөн иргэний гаргасан зөрчил нь Сэлэнгэ-Дархан-Уул аймгийн чиглэлд хяналтын хурдны камераар илэрсэн зөрчил болох нь тогтоогдсон бөгөөд цагдаагийн алба хаагчийн буруутай үйлдэл тогтоогдоогүй талаар иргэнд хариу мэдэгдсэн болно.
66.	2022.04.27 11:50	168075	Хүсэлт	Би 2013 оны 11 дүгээр сарын 4-нд Б.Мөнх-Эрдэнэ буюу төрсөн охиноо нөхрийнх нь гарт алдсан юм. Чингэлтэй дүүргийн цагдаагийн 1 дүгээр хэлтсийн мөрдөн байцаагч, дэслэгч Ганжаргалд өргөдөл өгсөн боловч та энэ талаар хөөцөлдөөд нэмэргүй таны охин амиа хорлосон гээд цэргийн эмнэлгээс амиа хорлосон гэсэн дүгнэлт гаргаж хавтаст хэргийг хаалаа гэж мэдэгдсэн. Тухайн үед миний охин 2 хүүхэдтэй үлдсэн бөгөөд 2 хүүхэд нь гэрч болж миний ээжийг "аав" зодсон гэж хэлсэн	Иргэний гомдолд дурьдсан эрүүгийн хэргийг 2013 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр Чингэлтэй дүүрэг дэх цагдаагийн Нэгдүгээр хэлтсийн мөрдөн байцаагч, цагдаагийн дэслэгч Ц.Г шалгаад хэргийг хэрэгсэхгүй болгох саналтай дүүргийн Прокурорын газарт хүргүүлсэн байна. Иймд гомдлоо Нийслэлийн прокурорын газарт гаргах нь зүйтэй талаар Мөрдөн байцаах албанаас 2022 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 12/1-2573 дугаар албан бичгээр иргэн Н.Оюунд хариу мэдэгдсэн.
67.	2022.05.10 03:59	176656	Гомдол	Би эргүүл хамгаалалтын албанд ажилладаг. Өмнө нь цагдаагийн байгууллагын 100 жилийн ойд зориулж 2 өдрийн цалинг татаж авсан, одоо дотоодын цэргийн 100 жилийн ой гээд 1 өдрийн цалинг авна гэж байна. Эргээд зардал тайлан тооцоо бидэнд мэдээлээгүй. Ингэж цалингаас	Цагдаагийн ахлагч Ш.Алтанбаатарын гомдлын дагуу шалгалтын ажиллагаа явуулахад Дотоодын цэрэг үүсэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ойд алба хаагчид сайн дурын үндсэн дээр хандив өгөхөд Ш.Алтанбаатар оролцоогүй байх бөгөөд алба хаагчдаас

				мөнгө татах нь зөв үү? Томилолтын мөнгө одоо болтол өгөөгүй байгаа, гэтэл цалингаасаа ингэж мөнгө хураалгах нь хүндрэлтэй байна. Холбогдох байгууллага руу уламжилж өгнө үү.	албадан хандив авсан гэх асуудал тогтоогдоогүй болно. Цагдаагийн ахлагч Ш.Алтанбаатар нь асуудлыг буруу ойлгож, Засгийнгазрын "Иргэд, олон нийттэй харилцах төв" /11-11/-ийн дугаарт гомдол гаргасан, ямар нэгэн гомдол саналгүй талаар тайлбар өгсөн.
68.	2022.05.12 13:50	178964	Гомдол	Хууль сахиулах хотхонд 2021 оны 8 сард орсон. Гэтэл одоог хүртэл манай байрны гэрчилгээ гараагүй улсын онцгой комисс хүлээж аваагүй гэх юм. Энэ асуудлаас болоод энэ хотхоны оршин суугчид хохирч байна. Байрныхаа гэрчилгээг яаралтай авах хүсэлтэй байна. Энэ байрны оршин суугчид 100 хувь төлбөрөө төлсөн. \\\"Бавгар\\\" ХХК энэ орон сууцыг банкны барьцаанд тавьчихсан байгаа юм. Цагдаагийн ерөнхий газраар зуучлуулж энэ барилгад бид захиалга өгсөн юм. Энэ асуудлыг маш яаралтай шийдвэрлэж	Цагдаагийн ерөнхий газрын Дотоод хяналт-Аюулгүй байдлын газраас 2022 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 36/4380 дугаар албан бичгээр хариу өгсөн болно.
69.	2022.05.06 16:34	175203	Гомдол	Түгжрэлийн асуудлаа шийдээгүй байж түр 2-3 минут зогсоод гарахын хооронд хувь хүмүүс зураг аваад дараа нь торгууль ирээд байна. Энэ зураг авч байгаа хүмүүс хаана хэнтэй гэрээ байгуулсан юмбэ? Ингэж төсөв бүрдүүлэхээр болсон юм уу? энэ асуудлыг холбогдох газар нь уламжилж өгнө үү.	Тээврийн цагдаагийн албаны Замын хөдөлгөөний удирдлагын хэлтсээс иргэний гомдолд шалгалтын ажиллагаа явуулж, 2022 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 14-1в/437 дугаар албан бичгээр иргэн Ч.Жамъянд хариу мэдэгдсэн болно.
70.	2022.05.05 10:25	173691	Гомдол	Осол хийсэн машиныг оношилгоонд заавал оруулах ёстой гээд 88.000 төгрөг нэхэмжилж байна. Тэгээд энэ оношилгоогоор нь дугуйны хээ л хэмжиж байна. Ингэж иргэдийг дарамталж болохгүй шүү дээ. Холбогдох газар нь уламжилж өгнө үү.	Тээврийн цагдаагийн албанаас Оношилгооны төлбөртэй холбоотой асуудлаар Авто тээврийн үндэсний төвд хандах талаар 14-3а/1646 дугаар албан бичгээр хариу өгсөн болно.
71.	2022.05.04 12:30	173020	Гомдол	Би 12 цагт гэртээ байсан. Гэтэл замын хөдөлгөөнд оролцоогүй байхад 11 цаг 52 минутад замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн гэж торгуулийн хуудас ирсэн. Тус торгуулийг төлөхгүй би санал нийлэхгүй байна. Тухайн үе миний автомашин нь байрны гадаа зогсож байсан. Энэ асуудлыг тодруулж өгнө үү.	Тээврийн цагдаагийн албанаас холбогдох шалгалтыг явуулж, Зөрчлийн тухай хуулиар торгуулийн арга хэмжээ ногдуулсан нь хууль зүйн үндэслэлтэй талаар 14-1в/457 дугаар албан бичгээр иргэн С.Эрдэнэд хариу мэдэгдсэн болно.
72.	2022.05.03 12:32	172033	Гомдол	Иргэн миний бие харшилтай учраас машиныаа урд хар теньтэй. Гэтэл эхнэр маань авто машиныг маань унаж яваад 20000 төгрөгөөр торгуулсан байна. Замын цагдаа нар иргэний гаргасан зөрчлийг шууд торгох биш тухайн иргэний гаргасан зөрчлийг арилгуулж сануулах арга хэмжээ авах эсвэл тодорхой хугацаа өгөх боломж олгодог байж	Тээврийн цагдаагийн албанаас 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 14-1д/729 дүгээр албан бичгээр иргэн Э.Чингист хариу өгсөн болно.

				болохгүй юу?. Торгуулиад явах эсвэл торгуулахгүйгээр зөрчлийг арилгуулах гэх мэтчилэн. Гэтэл манай улсын төрийн байгууллагууд болон эрх мэдэлтэй хүмүүсийн авто машинууд бүгд хар тенгтэй	
73.	2022.05.03 09:06	171613	Санал	Цахилгаан дугуйг явган хүний замаар битгий явуулаач гэсэн саналтай байна. Энэ асуудлыг холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлэж өгнө үү.	Тээврийн цагдаагийн албанаас 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 14-1д/731 дүгээр албан бичгээр иргэн Ч.Оюунбилэгт хариу мэдэгдсэн болно.
74.	2022.04.28 10:59	168906	Хүсэлт	Онлайн мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа явуулдаг 1xbet болон poker тоглоомын сайтуудыг хориглож, энэ асуудлыг яаралтай шийдвэрлэх шаардлагатай байна. Энэ асуудлаас болж маш олон залуучууд амьдралаараа хохирч, их хэмжээний мөнгө гадаадын зах зээлрүү урсаж байна. Үүнээс гадна амиа хорлолт, гэр бүл салалт ихээр нэмэгдэж иргэд их хэмжээний зээл тавьж байна. Эдгээр сайтуудад бооцоо тавих эх үүсвэр нь Монгол улсын иргэдийн дансаар дамжиж явагддаг учраас үүнд хатуу хяналт тавьж өгнө үү. Энэ	Иргэний гомдлын дагуу Эрүүгийн цагдаагийн албанаас шалгалтын ажиллагаа явуулж, 1xbet3 нэртэй цахим мөрийтэй тоглоомтой холбоотой хэрэг нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн хэлтсүүдэд шалгагдаж байгаа талаар иргэн Д.Баттүвшинтэй 8800... дугаарын утсаар холбогдож, хариу өгсөн.
75.	2022.04.28 14:08	169221	Гомдол	Онлайнаар покер, мөрийтэй тоглоом тоглуулдаг газруудаа хаагаач ээ. Эрүүгийн цагдаагийн албанд өргөдөл өгөөд байхад л хаахгүй байна. Тэд чинь дансныхаа дугаарыг солиод л мөрийтэй тоглоом зохион байгуулаад байна шүү дээ. Энэ асуудлыг холбогдох байгууллагад нь уламжилж, яаралтай арга хэмжээ авна уу.	Эрүүгийн цагдаагийн албанаас холбогдох шалгалтыг явуулахад иргэний гомдолд дурьдсан асуудлыг нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн хэлтсээс хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналтай прокурорын байгууллагад хүргүүлж, иргэнд хариу мэдэгдсэн байна.
76.	2022.04.29 11:28	169816	Хүсэлт	Цахим мөрийтэй тоглоомын асуудлыг хяналтдаа авч өгнө үү. 89274742 дугаараас нэр хүндийн баталгаа, бид найдвартай бонус өгнө гэсэн зурвас иргэдийн гар утсанд илгээж цахим мөрийтэй тоглоом, цахим зээлд уриалан дуудаж байна. Энэ асуудалд хяналт шалгалт тавьна уу. Холбогдох газарт нь уламжилж өгнө үү.\n\n	Эрүүгийн цагдаагийн албанаас холбогдох шалгалтыг явуулахад 89274742 дугаарын утас нь холбогдох боломжгүй байсан бөгөөд тухайн дугаараас мөрийтэй тоглоом болон бусад зар мэдээ нийтэлсэн байдал тогтоогдоогүй болно.
77.	2022.04.26 16:43	167610	Гомдол	2022 оны 3-р сарын 27-нд төрсөн дүү маань 39 насандаа Эрдэнэт хотод амьдрах авга эгчийн хүүд онц хэрцгийгээр алуулсан. Дүүгийн маань хоолойны гүрээний судсыг тасалж, гэдсэнд нь хутгалаад, 2 гуаыг нь хөх няц болтол нь юмаар цохиод алчихсан. Гэтэл Орхон аймгийн цагдаагийн газар нотлох баримтгүй, наад хүн чинь амиа хорлосон гээд хаачихсан. Хүн амины онц ноцтой	Орхон аймаг дахь цагдаагийн газраас 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдөр хохирогч Г.Б, түүний хүргэн Х.Б нартай уулзаж гомдол, мэдээллийн хариуг өгсөн. Хохирогч, гэрч нараас мэдүүлэг авч, шинжээчийн дүгнэлтийг танилцуулсан. Мөн газрын алба хаагчид хэрэг бүртгэлтийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.

				хэрэг гарчихсан байхад цагдаа нар яагаад ажлаа хийхгүй байгаа юм бэ. Алуурчин нь одоо	
78.	2022.05.13 15:58	180365	Гомдол	Сонгинохайрхан дүүргийн 13 хороонд зуслангийн газар өмчлөх эзэмшихээр аваад удаан хугацаанд амьдарч байна. Тухайн газраа гадаа 00 хийх гээд ухуулах гэхээр экологийн цагдаагийн албанаас ухаж байгаа экскаваторын жолоочийн бичиг баримтыг хурааж аваад байх юм. Манай 00 дүүрээд шинээр ухуулах хэд хэдэн удаа ухуулах гээд чадсангүй. Энэ асуудлыг холбогдох байгууллагад нь уламжлан шийдвэрлэж өгнө үү. (Бичлэг сонсох)	Экологийн цагдаагийн албанаас холбогдох шалгалтыг явуулахад зөрчлийн шинжтэй нөхцөл байдал тогтоогдоогүй бөгөөд иргэн Ц.Гэрэлмаа гомдол саналгүй талаар тайлбар өгсөн болно.
79.	2022.05.12 10:51	178722	Гомдол	Баянзүрх дүүргийн 8 дугаар хороо Ботаникийн эцэст "Бавгар" ХХК 2015 онд "Хууль сахиулагч хотхон" цагдаагийн албан хаагч нарын орон сууцанд захиалга авсан боловч одоог хүртэл ашиглалтад ороогүй байна. Гомдлоо гаргахаар шийдвэрлэнэ гэж хэлээд олон жил болж байна. Энэ асуудлыг шийдвэрлэж, захиалга өгсөн иргэдийг эрх ашгийг хамгаалж өгнө үү.	Цагдаагийн ерөнхий газрын Дотоод хяналт-Аюулгүй байдлын газраас 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 36/4411 дүгээр албан бичгээр иргэн Д.Дашзэвэгт хариу өгсөн болно
80.	2022.04.28 14:15	169238	Санал	Машины торгууль хаана юунд зарцуулагдаж байгааг иргэд мэдмээр байна. Өдөрт хэдэн арван машин торгож байна. Нээлттэй болгомоор байна шүү дээ. Энэ асуудлыг холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлэж өгнө үү.	Тэврийн цагдаагийн албанаас 9053.... дугаарын утсаар иргэнтэй холбогдож, хариу өгсөн болно
81.	2022.04.29 16:21	170247	Гомдол	Би 2016 онд машинаа зараад 2021 он хүртэл машин бариагүй юм . Гэтэл 2016 оноос хойш миний нэр дээр торгууль тавигдаж 5 оноо хасагдсан гэж E-Mongolia цахим системд гарч ирж байх юм. Замын цагдаа нар РД асуудгийг болиулмаар байна. Тухайн иргэн өөр хүний РД хэлж байж болзошгүй. 2016 оноос хойш машин барьж замын хөдөлгөөний зөрчил гаргаагүй тул энэ асуудлыг холбогдох газар нь уламжилж, шийдвэрлэж өгнө үү.	Тэврийн цагдаагийн албанаас 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 14-2а/1348 дугаар албан бичгээр хариу өгсөн болно.
82.	2022.05.10 03:01	176543	Гомдол	2021 оны онд Дүнжингаравын зам дээр автомашинаараа хурд хэтрүүлсэн гэж 2 удаа торгууль ирсэн юм. Энэ талаар гомдол гаргаж зөрчилгүй гэсэн шийдвэр гарч торгуулиа устгуулсан юм. Гэтэл өнөөдөр шалгахад хугацаа болон байршлыг нь өөрчилж дахин торгууль бичсэн байна. Энэ асуудлыг холбогдох газарт нь уламжилж иргэнтэй холбогдож мэдээлэл авч, хариу өгнө үү.	Тэврийн цагдаагийн албаны Замын хөдөлгөөний удирдлагын хэлтсээс 2022 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 14-1в/458 дугаар албан бичгээр иргэнд хариу өгсөн болно.

83.	2022.05.09 10:24	176346	Гомдол	Баянзүрх дүүргийн 14 дүгээр хороонд машинаа зам дагуу тавихад замын цагдаагийн газраас өглөөний 06:00 цагт торгууль бичээд байна. Зогсоолийн зай талбай хүрэлцэхгүй байхад ингэж болдог юм уу ? Энэ асуудлыг холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлэж өгнө үү.	Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн газрын замын цагдаагийн хэлтсээс иргэний гомдол гаргасан 8807... дугаарын утсаар холбогдоход " энэ дугаар дээр тийм нэртэй хүн байхгүй, би гомдол гаргаагүй" гэсэн хариу тайлбар өгсөн.
84.	2022.05.12 11:54	178842	Гомдол	Баянзүрх дүүргийн 9 дүгээр хорооны уулзвар дээр зохицуулагч хийж байгаа замын цагдаа 1 дүгээр эгнээнд зогссон гээд 25-36 ДГА улсын дугаартай машиныг 10 нэгжээр торгосон. Хүүхдээ сургуулиас нь аваад суулгах хооронд ирээд өөрийн нэрээ танилцуулахгүй торгож байна. Энэ асуудлыг холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлэж өгнө үү.\	25-36 ДГА улсын дугаартай автомашины жолооч Т.Баярмаа нь Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 2.27 тэмдгийн үйлчлэлийн хүрээнд түр зогсож Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 35 дах хэсэгт заасны дагуу торгуулийн арга хэмжээ авсан талаар Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн газрын Замын цагдаагийн хэлтсээс иргэнд тайлбарлаж өгсөн болно.
85.	2022.05.13 15:45	180303	Санал	Дугуй, мопид унаж байгаа иргэдийг журамлах хэрэгтэй байна. Дүрэмгүйгээр хурдтай явсаны улмаас машинд мөргүүлэх, машин мөргөх , замын хөдөлгөөнд оролцож байхдаа өөрөө гэмтэх, бусдын эд хөрөнгө гэмтээх, саад учруулах зэрэг олон асуудал үүсгэдэг. Холбогдох газар нь уламжилж өгнө үү.	Тээврийн цагдаагийн албанаас 2022 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 14-1д/798 дугаар албан бичгээр иргэнд хариу өгсөн болно.
86.	2022.05.16 16:57	182054	Санал	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд оролцож байгаа цахилгаан дугуйд тээврийн хэрэгслийн бүртгэл хийлгэмээр байна, унах насны хязгаартай баймаар байна, барих үнэмлэхтэй баймаар байна. Ямар нэгэн осол болвол замын хөдөлгөөний аюулгүй байдалд ямар хууль дүрэм журмаар зохицуулагдах вэ? холбогдох газар нь уламжилж өгнө үү.	Тээврийн цагдаагийн албанаас 2022 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 14-1д/797 дугаар албан бичгээр иргэнд хариу өгсөн болно.
87.	2022.05.11 16:01	178305	Хүсэлт	Авто машины зөрчил илрүүлсэн торгуулийг маш хурдан цаг тухайд нь ирдэг болгомоор байна. Тухайн үед нь л явуулахгүй болохоор хаана хэзээ зөрчил гаргаснаа тодорхой санахгүй байгаагаас гадна нэг ирэхдээ овоорч ирээд байна. Холбогдох харьяа байгууллагад нь уламжилж өгнө үү.	Тээврийн цагдаагийн албанаас 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 14-1в/481 дүгээр албан бичгээр иргэнд хариу өгсөн болно.
88.	2022.05.04 10:33	172770	Санал	Цагдаагийн Сүлд чуулгыг татан буулгах саналтай байна. Сүлд чуулгын дуучид үеийн үед офицер цолтой байгаагүй. Дарга нарт мөнгө өгөөд цол аваад байдаг. Үнэхээр байлгамаар байвал ахлагч цолтой нь байлгаач гэсэн саналтай байна. Энэ асуудлыг холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлэж өгнө үү.	2022 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 36/4382 дугаар албан бичгээр иргэн Б.Цэвэлмаад хариу мэдэгдсэн болно.

89.	2022.05.04 15:39	173296	Гомдол	<p>Баянгол дүүргийн Мэргэжлийн хяналтын байцаагч 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдөр гаргасан гомдлын дагуу надтай холбогдсон. Баянгол дүүргийн 6 дугаар хороо Улаанбаатар паласын хажууд байдаг "КОКО БАНАНА" шөнийн цэнгээний газар цар тахлын үед хүртэл ажиллаж байсан. Нийслэлийн цагдаагийн газарт хандсан ч ямар нэгэн арга хэмжээ авч өгөөгүй. Баянгол дүүргийн 2 дугаар хэлтсийн цагдаа нар нь дээрх газартай харилцан холбоотой ажилладаг. Дээрх газрын үйл ажиллагааг зогсоох хүсэлтэй байна. Иргэдийн амгалан тайван байдлыг алдагдуулж байна.</p>	<p>Баянгол дүүрэг дэх цагдаагийн газраас 2022 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 26е/2394 дүгээр албан бичгээр цагдаагийн алба хаагчийн буруутай үйлдэл тогтоогүй талаар иргэнд хариу мэдэгдсэн.</p>
-----	---------------------	--------	--------	--	---

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ТӨЛӨВЛӨЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТЭС